



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 15 өдөр

Дугаар АА2

Булган сум

Аймгийн музейн үзэл баримтлалыг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.7, 66 дугаар зүйлийн 66.1, Музейн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн музейн “Үзэл баримтлал”-ыг хавсралтаар баталсугай.
2. Музейн үзэл баримтлал батлагдсантай холбоотой үзүүлэг дэглэлтийн төлөвлөгөөг батлуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллахыг аймгийн музейн захирал (Т.Бэхтөр)-д үүрэг болгосугай.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг Соёл урлагийн газрын дарга (Г.Алдармөнх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  БАРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2023. оны
11. дугаар сарын 15-ны өдрийн 11/12 дугаар
захирамжийн хавсралт

БУЛГАН АЙМГИЙН МУЗЕЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ
НЭГ. ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Монгол Улсын Их Хурлын 2020 оны намрын чуулганаар батлагдсан Музейн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.2 дахь заалтад “музейн үзэл баримтлал гэж музейн төрөл, үйл ажиллагааны чиглэл, хамрах хүрээ, цуглуулгын болон үзүүлэгийн бодлогыг тодорхойлсон баримт бичгийг” гэж, 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Музейн үзэл баримтлалыг үүсгэн байгуулагч нь батлах бөгөөд орон нутгийн болон хувийн өмчийн музейн үзэл баримтлалыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөнө” гэж, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Аймаг, нийслэлийн болон сумын музей орон нутгийн байгаль, түүх, соёлын үнэт зүйлийг бүртгэх, цуглуулах, хадгалж хамгаалах, судлах, сурталчлах болон түгээн дэлгэрүүлэх чиг үүрэгтэй байна” гэж тус тус заасны дагуу Булган аймгийн музейн үзэл баримтлалыг боловсрууллаа.

Булган аймгийн музей нь 1952 онд аймгийн Гэгээрлийн хэлтсийн даргын 14 дүгээр тушаалаар “Орон нутгийн судлах кабинет” нэртэйгээр байгуулагдсан бөгөөд 1965 онд Баруун замын тусгай ангийн үйл ажиллагааг алдаршуулах зорилгоор Сүмтийн пүүсийн хуучны барилгад Штаб музейг, 1970 онд Хатанбаатар Магсаржавын дурсгалыг мөнхжүүлэх зорилгоор түүний шарилыг хадгалсан Дуулгат бунханыг ашиглалтад оруулан харьяалуулжээ. Аймгийн музей нь өнгөрсөн хугацаанд орон нутгийн байгаль, түүхийн үнэт зүйлийг цуглуулах, сурталчлах, хадгалан хамгаалах чиг үүргийг төрийн болон орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуудан хэрэгжүүлж, олон нийтийг соён гэгээрүүлэх үйлсэд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн байна. Музей нь нийгмийн өмнө хүлээсэн үүргээ зохих түвшинд хэрэгжүүлж ирсэн ч хүний нөөцийн чадавх, барилга байгууламжийн хүчин чадал, сан хөмрөгийн баяжилт зэрэг хүчин зүйлээс шалтгаалан өрсөлдөх чадвар нь сул хэвээр байна. Ялангуяа музейд харьяалуулсан Штаб музей, Дуулгат бунханы үйл ажиллагаа музейн үндсэн үйл ажиллагааны тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж, байгаа нөөцийг зохистой хуваарилж ашиглахад бодит бэрхшээл учруулж байна. Цаашид төрийн болон орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулан музейн сан хөмрөгийг баяжуулах, үзүүлэгийн танхимыг сэдэвчлэн дэглэх, үйлчилгээний нэр төрлийг олшруулж, чанар хүртээмжийг дээшлүүлэх, эрдэм шинжилгээний ажлын үр өгөөжийг сайжруулах, үзмэр эд өлгийн зүйлийн аюулгүй байдлыг хангах, ажилтан албан хаагчдыг мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зэргээр музейн чадавхыг бүх талаар бэхжүүлж, өрсөлдөх чадварыг орчин үеийн музейн түвшинд хүргэн, хуримтлагдсан нөөцийг зохистой удирдлагаар хангаж ажиллах бодит хэрэгцээ шаардлага тулгамдаж байна.

Музей бол аливаа улс үндэстний байгалийн болон соёлын үнэт зүйлсийг хадгалж хамгаалах, сонирхогч талуудад олон талт арга хэлбэрээр сурталчлан таниулах замаар бүх нийтийн хөгжлийг дэмжиж, нийгмийн нэгдмэл тогтвортой, сайн сайхан байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг соёл, боловсрол, шинжлэх ухааны байгууллага юм. Тийм ч учраас дэлхийн улс орнууд музейн нийгмийн хөгжилд оруулж буй эерэг

нөлөөллийг олон хэлбэрээр хөхиүлэн дэмжиж, өмчийн бүх хэлбэрийн музейг хамруулсан үндэсний сүлжээг бэхжүүлж, тогтвортой хөгжлийг хангахад ихээхэн хүчин чармайлт гаргаж байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Үндэсний нэгдмэл үнэт зүйл” хэсэгт “Төрт ёсны уламжлал, түүх, соёлын дурсгал, утга зохиол, урлагийн бүтээлээр үндэсний бахархал төлөвшүүлэх, эх оронч үзэл, эв нэгдлийг нягтруулна”, “Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээгч монгол хүн төвтэй нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болно”, “Үнэт зүйлийн удалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэл болсон монголын түүх, хэл, соёл, ёс заншил, нүүдлийн соёл иргэншил, шашин, гүн ухааны судалгааг хийж нийтийн хүртээл болгон хэвшүүлж, нийгмийн соён гэгээрлийг өндөр түвшинд хүргэнэ” гэж дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг бүс нутгийн болон орон нутгийн түвшинд хангахад аймгийн музейн үүрэг оролцоонд тулгуурлан зэрэг өөрчлөлтийг нэмэгдүүлж, эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг дээшлүүлэх шаардлагатай байна.

ХОЁР. МУЗЕЙН ТӨРӨЛ

Булган аймгийн газар нутаг нь Монгол орны умард хэсгийг голлон говь, хээр, ойт хээрийн бүсэд байрладаг, байгалийн болон соёлын өвийн баялаг нөөцтэй үзэмж төгс нутаг юм. Аймгийн нутаг дэвсгэр дээр Хөгнөхан, Булганхан, Бүрэгхангай, Дулаанхан, Хантайн нуруу, Бүтээлийн нуруу зэрэг томоохон уул нурууд байрлаж, Орхон, Сэлэнгэ, Туул, Эг зэрэг гол мөрнүүд урсан өнгөрдөг. Шарга, Харгал, Айрхан зэрэг томоохон нуурууд бий. Ургамлын бүрхэвч, амьтны аймгийн хувьд говь, хээр, ойт хээрийн бүсийн нийтлэг шинжийг агуулдаг. Уран тогоо, Тулга зэрэг байгалийн өвөрмөц тогтоц, Хулж, Хануй, Хунт, Асгатын зэрэг олон төрлийн өвчнийг анагаах шидтэй халуун хүйтэн рашаан устай.

Булган аймгийн нутаг дэвсгэр дээр эрт үед хүн аж төрж ирснийг гэрчлэх олон арван түүхийн дурсгал хадгалагдаж үлдсэн. Томоохон голын хөндий дагасан эртний чулуун зэвсгийн дурсгалт газар, хүрэл төмрийн үеийн дурсгалууд, эртний улсуудын үеийн хэрэм балгасаас гадна хуучны бичгийн дурсгал, хүрээ суурингийн үлдэгдэл элбэг тохиолдоно. Эртний дурсгалаас түүх, соёл, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдолтой Майхан уулын Шороон бумбагарын бунхант булш, Цогт хунтайжийн цагаан байшин, Бийбулаг, Чинтолгой, Харбух, Эмгэнтийн зэрэг эртний хот хэрмийн үлдэгдэл, Мааньт, Цахиуртай, Ингэттолгой, Цацын дэнжийн Байширын бүрд, Шивээт улааны хөшөөд, Эгийн голын хөндий, Их бага Төлбөрийн гол, Бухын манхан, Тарвагатайн хөндийн чулуун зэвсгийн дурсгалт газар зэрэг түүхийн олон үед холбогдох дурсгалууд байрладаг.

Булган аймагт халх, буриад угсаатны бүлэг зонхилон амьдардаг бөгөөд тэдний нүүдлийн уламжлалт аж ахуй, соёлын биет болон биет бус өвийн илэрхийллийг харьцангуй язгуур хэв шинжээр нь хадгалж үлдсэн газар нутаг юм. Түүнчлэн, тус аймаг нь ардын хувьсгалын жилүүдэд батлан хамгаалах, хөдөө аж ахуй, соёл урлаг, шинжлэх ухаан, боловсрол, ашигт малтмал зэрэг бүхий л салбарт төрөн гарсан “анхны” гэгдэх олон арван баатарлаг, гавъяат үйлстэн алдартнуудаараа онцгойрдог.

Булган аймгийн музей нь дээр дурдсан үнэт зүйлсэд тулгуурласан говь, хээр, ойт хээрийн байгалийн үнэт зүйлс ба анхдагчдын түүхэнд холбогдох үнэт зүйлсийг бүртгэх, судлах, хадгалах, сэргээх, сурталчлах, ашиглах чиг үүрэг бүхий байгаль-түүхийн хосолмол төрлийн сэдэвчилсэн музей байна.

ГУРАВ.МУЗЕЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Булган аймгийн музейн үйл ажиллагааны үндсэн зорилго нь аймгийн байгалийн бүс бүслүүрийн үзэмжит байдал, чулуун зэвсэг ба хүрлийн үе, эртний улсуудын түүхэнд холбогдох соёлын биет болон биет бус өвийн баялаг байдлыг илэрхийлэх соёлын үнэт зүйлсийг цуглуулах, судлах, хадгалах, сурталчлах, мэдлэг түгээх үндсэн зорилготой музей байна. Музейн үйл ажиллагааны чиглэл нь Монгол Улсын Музейн тухай хуулийн 7.1-д зааснаар тодорхойлогдох ба холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хүний хөгжлийг дэмжих, соёлын хэрэгцээг хангах, тав тухтай байдлыг бүрдүүлэхэд чиглэсэн номын сан, хүүхдийн тоглоомын танхим, бэлэг дурсгалын дэлгүүр, кофе шоп, цахим түгээлтийн үйлчилгээг эрхэлнэ. Музейн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл нь сэдвийн хүрээний байнгын үзүүлэлийн танхимын үйлчилгээнд тулгуурлах бөгөөд үзмэр, эд өлгийн зүйлийг сурвалжлан олж цуглуулах, тэдгээрийг судалж шинжлэх, олон нийтэд хүртээмжтэйгээр сурталчлах чиглэлд гол ач холбогдол өгч ажиллана. Байгалийн шинжлэл, археологи, угсаатны зүйн судалгаа нь музейн тэргүүлэх судалгааны чиглэл болно. Музей нь үйл ажиллагааны үндсэн чиглэл болон бусдаас ялгарах онцлог агуулгатай эрдэм шинжилгээний бичиг, сурталчилгааны сэтгүүлтэй байна.

Музейн үйл ажиллагаа нь бүс нутгийн болон аймгийг хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлоготой нягт уялдана. Ялангуяа бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд заасан аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого, бүх нийтийг соён гэгээрүүлэх бодлого, соёлын өвийг хамгаалах бодлого зэрэг хөгжлийн бодлого, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлоготой сайтар уялдуулж, хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ.МУЗЕЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Булган аймгийн музей нь үндсэн чиглэлийн хүрээнд аймгийн нутаг дэвсгэрийг хамруулсан судалгаа, шинжилгээний ажлыг хэрэгжүүлнэ. Хил залгаа ОХУ-тай хамтран хоёр талын нутаг дэвсгэрт байгаль, түүх, археологийн хамтарсан судалгааны төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх стратеги баримтлан ажиллана. Буриад зон олны аж төрж байгаа бүс нутагт экспедици ажиллуулж, соёлын үнэт зүйлийг цуглуулах ажлыг зохион байгуулна.

Музей нь сэдвийн хүрээнд өөрийн улсын болон гадаад улсын музей, судалгааны байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж, хамтарсан үзэсгэлэн гаргах, судалгааны төсөл хэрэгжүүлэх, хамтарсан ном бүтээл хэвлүүлэх, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулна.

ТАВ.МУЗЕЙН ЦУГЛУУЛГА

Булган аймгийн музейн цуглуулгын бодлого Булган аймгийн говь, хээр, ойт хээрийн чулуулаг, хөрс, ургамал, амьтны аймгийг төлөөлөх, анхдагчдын түүхэнд холбогдох соёлын үнэт зүйлсийг биетээр цуглуулахад чиглэнэ. Цуглуулгын бодлогыг Монгол Улсын Музейн тухай хуулийн 8.2-т заасан хугацаагаар төлөвлөж, хэрэгжүүлнэ.

Музейн байгалийн сэдэвтэй цуглуулгын зарим хэсэг /амьтны чихмэл/-ийг орчин үеийн технологийн шийдэлд тулгуурлан хиймэл материалаар орлуулж, бүтээхийг эрмэлзэнэ. Музейн соёлын биет өвийн цуглуулгын хуулбар хувь нийт цуглуулгын 1 хувиас ихгүй байна.

ЗУРГАА.МУЗЕЙН ҮЗҮҮЛЛЭГ

Булган аймгийн музейн үзүүллэгийн нийт талбайн 30-аас багагүй хувь нь Булган аймгийн байгалийн үзэмжит байдлыг, 30-аас багагүй хувийг анхдагчдыг алдаршуулж, мөнхжүүлэх, 10-аас багагүй хувийг буриад угсаатны бүлгийн соёлын биет болон биет бус өвийн баялаг байдлыг илэрхийлсэн байна. Мөн үзүүллэгийн танхимын 30 орчим хувийг археологийн үзүүллэг дэглэлт эзэлнэ.

Сэдэв бүр өөр хоорондоо утга агуулга, учир зүйн холбоо хамааралтай, үзмэрийн дэглэлт агуулгыг бүрэн илэрхийлж, нэгдмэл цогц ойлголтыг өгөхүйц хэмжээнд тавигдана. Үзүүллэг дэглэлтийн орон зайг дижитал технологиор баяжуулан, бодит үзмэрийн өгөгдлийг үнэр, дуу чимээ, өнгө дүрсний шийдэлтэй хослуулан зохиомжилж, мэдлэг түгээх арга замыг хөнгөвчилсөн үйлчилгээг өргөнөөр ашиглана.

ДОЛОО.МУЗЕЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮР ӨГӨӨЖ

Булган аймгийн музейн үйл ажиллагаа бусад музейн нэгэн адил хүний хөгжлийг бүх талаар дэмжихэд чиглэнэ. Музей нь Булган аймгийн нийт иргэдийн аймаг орон нутгаараа бахархах сэтгэгдлийг төрүүлэх, үнэт зүйлийн нэгдмэл байдлыг бататган бэхжүүлэх, оюутан сурагчдын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, үзэгч үйлчлүүлэгчдэд өвөрмөц онцлог бүхий ой санамж, дурсамжийг үлдээх, орон нутгийн соёлын ялгаатай байдлыг хүндэтгэх үзэл санааг дэлгэрүүлэх зэрэг нийгмийн ач холбогдолтой байна. Цаашид аймгийн музей бүс нутагтаа тэргүүлэх, өрсөлдөх чадвар бүхий, өөрийн өвөрмөц хэв шинжийг тодотгосон музей болон хөгжинө.

Музей нь үзэгч, үйлчлүүлэгчийн хүсэл сонирхолд нийцсэн олон талт, чанартай, хүртээмжтэй, оролцоонд суурилсан үйлчилгээ үзүүлэх замаар орлогын хэмжээг өсгөж, улмаар аймгийн зочлох үйлчилгээ, хоол үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, соёлын бүтээлч үйлдвэрлэл, зугаа цэнгээн (караоке, диско бүжиг) зэрэг бусад салбарын орлогыг нэмэгдүүлэхэд дам нөлөө үзүүлнэ. Булган аймгийг зүүн бүсийн аялал жуулчлалын дамжин өнгөрөх төв болгон хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд чухал нөлөө үзүүлж, орон нутагт нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх боломжийг олгоно. Булган аймгийн музейн олон талт, идэвхтэй үйл ажиллагааны үр дүн аймгийн өрсөлдөх чадварын үзүүлэлтийг өсгөх ба музейн тогтвортой хөгжлийг хангахад чухал хувь нэмэр оруулах болно.